



## ТҮҮХЭН ДУРСГАЛТ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН ДУРСГАЛЫН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЗААВАР

### НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүчитгэлийн нөхцөл байдлын талаарх бодит мэдээллээр, удирдах дээд болон эрх бүхий байгууллага, хуулийн этгээд, олон нийтийг хангах эх сурвалж баримт болно.
2. Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 20.2; 21.1; 21.2; 23.2 дахь заалтын дагуу Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хадгалалт хамгаалалтын мэдээллийг бүрдүүлж, нэгтгэхэд энэхүү маягыг ашиглана.
3. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэрэг нь:  
Нэг. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын үндсэн мэдээлэл,  
Хоёр. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд хийсэн судалгааны ажлын мэдээлэл,  
Гурав. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эвдрэл гэмтэл, түүнийг зассан тухай мэдээлэл,  
Дөрөв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварласан тухай ерөнхий мэдээлэл гэсэн дөрвөн төрлийн хүснэгтэн мэдээллээс бүрдэнэ.
4. Дан болон цогцолбор байдлаар орших түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалуудад судалгааны ажил, хадгалалт хамгаалалт, сэргээн засварлалт, хүчитгэлийг хэрхэн хийсэн, судалгаа шинжилгээ, барилга байгууламжийн ажлын зураг байгаа эсэх, хэсэгчилсэн болон бүтэн байдлаар сэргээн засварласны дараах тайланг хадгалсан эсэх, ямар байгууллага хэрхэн хариуцаж, хяналт тавьдаг зэрэг нарийвчилсан мэдээлэл цуглуулна.
5. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийг тухайн барилга байгууламжийг эзэмшигч, өмчлөгч хуулийн этгээд, хувь хүн, аж ахуйн нэгж хөтлөн явуулах ба дээрх нэр бүхий дөрвөн төрлийн маягыг үзүүлэлт нэг бүрээр товчилсон үг хэрэглэхгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв, алдаагүй бөглөнө.
6. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийг жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны дотор Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.
7. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн эх хувийг хариуцагч байгууллагын бүртгэл, мэдээллийн санд хадгалах ба хуулбар 1 (нэг) хувийг цаасан хэлбэрээр болон цахимаар Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлнэ.
8. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягыг хүргүүлэхдээ хянасан байгууллагын захирал, хувийн хэрэг хөтөлсөн албан тушаалтан нар тус бүр гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэг дарж баталгаажуулсан байна.
9. Өмнөх жилүүдэд хийгдсэн сэргээн засварлалтын ажил болон холбогдох мэдээллийг нөхөж бүрдүүлнэ.

10. Хувийн хэрэг хөтлөх ажлыг маягтын дагуу мэдээллээр хангаж, баяжуулалт хийх замаар жил бүр шинэчилнэ.
11. МД-мөрийн дугаар болно.
12. Хуудасны дугаарлалтыг хуудас бүрийн баруун доод буланд "тухайн хуудасны дугаар/нийт хуудасны тоо" гэсэн форматаар бичнэ. Жишээ нь, тухайн маягт нийт 10 хуудастай бол 1/10 гэх мэт.
13. Соёлын өвийн үндэсний төвийн захирлын баталсан түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын хувийн хэргийн маягтын асуулга, агуулгыг өөрчлөхийг хориглоно.

### **Нэг. Түүхэн дурсгалт барилга, архитектурын Дурсгалын үндсэн мэдээлэл**

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо: Тухайн барилга дээр хувийн хэрэг хөтөлсөн өдрийг он/сар/өдөр дарааллаар бичнэ үү.

Дурсгалт газрын нэр: (Цогцолбор болон дан байдлаар орших барилга байгууламжийн ерөнхий нэрийг бичнэ үү. Жишээ нь, Богд хааны ордон музейн цогцолбор, Чин ван Ханддоржийн байшин гэх мэт)

Дурсгалт газрын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэлийн дугаар болох 8-9 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5)

- 1.1. **Засаг захиргааны нэгж:** Харгалзах мөрөнд ... улс ... аймаг/хот, ... сум/дүүрэг, ... баг/хороо, .... нэртэй газар гэсэн дарааллаар одоо байгаа хаягийг бичнэ үү.
- 1.2. **Түүхэн үе:** Монгол нутаг дахь эртний улсын үе, Их Монгол Улсын үе, Манжийн эрхшээлийн үе, Богд хаант Монгол Улсын үе, БНМАУ-ын үе гэх мэтээр бичнэ үү.
- 1.3. **Баригдсан он, цаг хугацаа:** Анх хэдэн онд барьж байгуулсан болохыг бичнэ үү. Хэрэв тодорхой бус байвал тоймлож бичнэ үү. Жишээ нь XVI зууны эхэн үе гэх мэтээр.
- 1.4. **Дурсгалын анхны зориулалт:** Тухайн барилга анх ямар зориулалтаар баригдсан болохыг бичнэ үү. Сүм хийд, хоршоо, эмнэлэг, сургууль, засаг захиргаа, театр, үйлдвэр гэх мэтээр.
- 1.5. **Өмчлөлийн хэлбэр:** Төрийн, орон нутгийн, олон нийтийн, шашны, иргэний, дундын гэсэн сонголтоос аль нэгийг сонгож харгалзах нүдэнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Бусад" сонголтыг сонгосон бол харгалзах мөрөнд бичиж оруулна уу.
- 1.6. **Одоогийн ашиглалтын хэлбэр:** Одоогийн байдлаар ямар зориулалтаар, ямар байгууллага үйл ажиллагаа явуулж байгааг бичнэ үү.
- 1.7. **Эзэмшлийн хэлбэр:** Төрийн, орон нутгийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн, дундын гэсэн сонголтоос аль нэгийг сонсож харгалзах нүдэнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Бусад" сонголтыг сонгосон бол харгалзах мөрөнд бичиж оруулна уу.
- 1.8. **Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ:** Гэрчилгээний дугаар, эзэмшигчийн нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ үү.
- 1.9. **Газрын гэрчилгээ:** Гэрчилгээний дугаар, эзэмшигчийн нэрийг товчлохгүй бүтнээр бичнэ үү.



- 1.10. Кадастрын зураг:** Өмчилсэн газрын гэрчилгээнд бичигдсэн газрын нэгж талбарын дугаарыг бичих ба Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 25.2 заалтыг үндэслэн Соёлын өвийн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулах ёстой. "Тийм" сонголт хийсэн бол арын харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Үгүй" сонголт хийсэн бол арын харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийнэ үү.
- 1.11. Хэв маяг:** Монгол, хятад, төвөд, классик, неоклассик, модерн сонголтоос аль нэгийг сонсож харгалзах нүдэнд (+) тэмдэглэгээ хийнэ үү. "Холимог" болон "Бусад" сонголтыг сонгосон бол харгалзах мөрөнд бичиж оруулна уу.
- 1.12. Хамгаалалтын зэрэглэл:** Улс, аймаг, нийслэл, сум дүүргийн алинд хамаарахыг харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийж Засгийн газрын тогтоол, шийдвэрийн нэр, огноо, дугаарыг бичнэ үү.
- 1.13. Солбицол:** Газар зүйн байршлыг уртраг, өргөрөгийн градус, минут, секундын утгаар бичиж оруулна уу.
- 1.14. Хамгаалалтын бүс тогтоосон эсэх:** "Тийм" сонголтыг хийсэн бол харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийж, бүсийн нийт талбайн хэмжээ, шийдвэрийн нэр, огноо, дугаарыг бичнэ үү. "Үгүй" сонголт хийсэн бол харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийнэ үү.
- 1.15. Орчны бүс тогтоосон эсэх:** "Тийм" сонголтыг хийсэн бол харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийж, бүсийн нийт талбайн хэмжээ, шийдвэрийн нэр, огноо, дугаарыг бичнэ үү. "Үгүй" сонголт хийсэн бол харгалзах мөрөнд (+) тэмдэглэгээ хийнэ үү.
- 1.16. Хэмжээ/давхар:** Барилгын урт, өргөн, давхрын тоо, тойргийн диаметр, таазны өндөр, бусад хэмжээг бичиж оруулна уу. Хэмжих нэгж М (метр) байна.
- 1.17. Барилгын материал/бүтээц:** Тухайн барилга ямар материалаар баригдсан болохыг бичнэ. Жишээ нь, мод, чулуу, тоосго, төмөр бетон, металл гэх мэтээр бичнэ үү.
- 1.18. Тоо ширхэг ба бүрдэл хэсэг:** Цогцолбор дурсгалыг бүхэлд нь 1 ширхэг гэж үзэх ба тус цогцолборыг бүрдүүлж буй байшин барилгын тоо ширхгийг бичнэ. Жишээ нь, Богд хааны ордон музей нь 1 цогцолбор, 16 барилга байгууламжаас бүрдэнэ гэх мэтээр.
- 1.19. Товч түүх:** Барилга хэрхэн баригдсан, зураг төслийг хэн гаргасан, ямар байгууллага, хувь хүн барьж гүйцэтгэсэн, тухайн үеийн нэршил, барилгын онцлог шинж гэх мэт мэдээллийг бичнэ үү.
- 1.20. Гэрэл зураг (хавсралтаар):** Гэрэл зургийг хамгийн сүүлийн байдлаар буюу одоо байгаа төрхөөр 4 талаас нь бүрэн бүтэн, аль болох халхлах зүйл (хүн, машин гэх мэт)-гүй орчинд авна. Зураг тус бүр 12x16см хэмжээтэй байх ба өнгөтөөр чанартай хэвлэсэн байна. Зургийг тайлбарын хамт хавсаргана уу.

**Хоёр. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд  
Хийсэн судалгааны ажлын мэдээлэл**

Тухайн барилга байгууламж цогцолбор буюу хоёроос дээш тооны барилга байгууламжтай бол "Хоёр. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалд хийсэн судалгааны ажлын мэдээлэл" хүснэгтийг барилга тус бүр дээр нэг бүрчлэн хөтлөхийг анхаарна уу.

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо: Тухайн барилга дээр хувийн хэрэг хөтөлсөн өдрийг он/сар/өдөр дарааллаар бичнэ үү.

Дурсгалт газрын нэр: (Цогцолбор болон дан байдлаар орших барилга байгууламжийн ерөнхий нэрийг бичнэ үү. Жишээ нь, Богд хааны ордон музейн цогцолбор, Чин ван Ханддоржийн байшин гэх мэт)

Дурсгалт газрын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэлийн дугаар болох 8-9 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5)

Дурсгалын нэр: (Тухайн дурсгал цогцолбор байдлаар буюу хоёроос дээш тооны барилга байгууламжаас бүрдэж байгаа бол энэ хэсэгт нэрийг нь бичнэ үү. Жишээ нь, Өвлийн ордон гэх мэт)

Дурсгалын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн дугаар болох 10-12 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5 15)

### **Баганын дугаар**

1. Судалгааг хэдэн онд хийсэн болохыг бичнэ үү.
2. Судалгааны ажлыг хэдэн төгрөгөөр, ямар байгууллага санхүүжилт хийсэн тухай харгалзах мөрөнд бичнэ үү.
3. Судалгаа хийсэн хувь хүний нэрийг эрдмийн зэрэг цолтой хамт харгалзах мөрөнд бичнэ үү.
4. Судалгаа хийсэн байгууллагын нэрийг харгалзах мөрөнд бичнэ үү.
5. Судалгаанаас гарсан дүгнэлт, тайлан, ном товхимол, сэтгүүл, гарын авлага зэргийн нэрийг бичнэ үү.
6. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29.1 заалтыг үндэслэн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулах ёстой. Хэрэв дээрх байгууллагаас өөр газарт хадгалагдаж байгаа бол тухайн байгууллага, хувь хүний нэр, албан тушаалыг бичнэ үү.

### **МД- Мөрийн дугаар**

**2.1- 2.12 хүртэл:** Харгалзах баганад тухайн судалгааны талаарх мэдээллийг нөхөж бичнэ. Мөрөнд бичсэнээс өөр төрлийн судалгаа хийсэн бол "Бусад судалгаа" хэсэгт нэрийг нь бичнэ. Судалгаа хийгээгүй бол харгалзах мөрийг хоосон орхино уу.

### **Гурав. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эвдрэл гэмтэл, түүнийг зассан тухай мэдээлэл**

Тухайн барилга байгууламж цогцолбор буюу хоёроос дээш тооны барилга байгууламжтай бол "Гурав. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалын эвдрэл гэмтэл, түүнийг зассан тухай мэдээлэл" хүснэгтийг барилга тус бүр дээр нэг бүрчлэн хөтөлхийг анхаарна уу.

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо: Тухайн барилга дээр хувийн хэрэг хөтөлсөн өдрийг он/сар/өдөр дарааллаар бичнэ үү.



Дурсгалт газрын нэр: (Цогцолбор болон дан байдлаар орших барилга байгууламжийн ерөнхий нэрийг бичнэ үү. Жишээ нь, Богд хааны ордон музейн цогцолбор, Чин ван Ханддоржийн байшин гэх мэт)

Дурсгалт газрын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэлийн дугаар болох 8-9 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5)

Дурсгалын нэр: (Тухайн дурсгал цогцолбор байдлаар буюу хоёроос дээш тооны барилга байгууламжаас бүрдэж байгаа бол энэ хэсэгт нэрийг нь бичнэ үү. Жишээ нь, Өвлийн ордон гэх мэт)

Дурсгалын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн дугаар болох 10-12 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5 15)

### **Баганын дугаар**

1. Барилга байгууламжийн хийц, хэсэглэлийн эвдрэл гэмтэл тухайн жилд ямар байсан талаарх мэдээллийг бичнэ үү.
2. Эвдрэл гэмтэлтэй хийц, хэсэглэлийг сэргээн засварлах талаар авч хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний тухай бичнэ үү. Холбогдох байгууллагад бичгээр өгсөн хүсэлт, заавар зөвлөгөө, сэргээн засварлалт хийсэн эсэх гэх мэт бүх төрлийн мэдээлэл орно.

### **МД- Мөрийн дугаар**

- 3.1. **Үндсэн хийц бүтээц:** Тухайн барилга байгууламжийн үндсэн араг яс буюу каркасыг бичнэ. Жишээ нь тоосгон өрөг, мод, дүнз, төмөр бетон, холимог гэх мэт.
- 3.2-3.5 **хүртэл:** Тухайн барилга байгууламжийн нүүр талыг 4 талаас нь харж, нүдэнд илт харагдах гэмтэл, элэгдлийг бичих ба сэргээн засварлалт хийхээс өмнө болон сэргээн засварлалт хийсний дараах байдлаар харьцуулан бичнэ үү. (Анхны төрх байдал алдагдсан эсэх, эвдэрч нурсан эсэх, үндсэн хийц бүтээц, материалд өөрчлөлт орсон эсэх гэх мэт). Сэргээн засварлалт хийж амжаагүй бол холбогдох байгууллагад мэдэгдсэн эсэх талаар мөн бичнэ үү.
- 3.6-3.16 **хүртэл:** Энэ хэсэг нь зөвхөн архитектурын дурсгал буюу сүм хийд, дуганы барилгад хамаарах ба сэргээн засварлалт хийхээс өмнө болон сэргээн засварлалт хийсний дараах байдлаар харьцуулан бичнэ үү. (Анхны төрх байдал алдагдсан эсэх, эвдэрч нурсан эсэх, үндсэн хийц бүтээц, материалд өөрчлөлт орсон эсэх гэх мэт). Сэргээн засварлалт хийж амжаагүй бол холбогдох байгууллагад мэдэгдсэн эсэх талаар мөн бичнэ үү.
- 3.17- 3.37 **хүртэл:** Барилга байгууламжийн бусад хэсэг, хийц, элемент нь тухайн хэсэгт сэргээн засварлалт хийхээс өмнө болон дараа ямар байдалтай болсон тухай бичнэ үү. (Анхны төрх байдал алдагдсан эсэх, эвдэрч нурсан эсэх, үндсэн хийц бүтээц, материалд өөрчлөлт орсон эсэх гэх мэт). Сэргээн засварлалт хийж амжаагүй бол холбогдох байгууллагад мэдэгдсэн эсэх талаар мөн бичнэ үү.

### **Дөрөв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг**

### сэргээн засварласан тухай ерөнхий мэдээлэл

Тухайн барилга байгууламж цогцолбор буюу хоёроос дээш тооны барилга байгууламжтай бол "Дөрөв. Түүхэн дурсгалт барилга, архитектурын дурсгалыг сэргээн засварласан тухай ерөнхий мэдээлэл" хүснэгтийг барилга тус бүр дээр нэг бүрчлэн хөтлөхийг анхаарна уу.

Хувийн хэрэг бүрдүүлсэн огноо: Тухайн барилга дээр хувийн хэрэг хөтөлсөн өдрийг он/сар/өдөр дарааллаар бичнэ үү.

Дурсгалт газрын нэр: (Цогцолбор болон дан байдлаар орших барилга байгууламжийн ерөнхий нэрийг бичнэ үү. Жишээ нь, Богд хааны ордон музейн цогцолбор, Чин ван Ханддоржийн байшин гэх мэт)

Дурсгалт газрын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газрын бүртгэлийн дугаар болох 8-9 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5)

Дурсгалын нэр: (Тухайн дурсгал цогцолбор байдлаар буюу хоёроос дээш тооны барилга байгууламжаас бүрдэж байгаа бол энэ хэсэгт нэрийг нь бичнэ үү. Жишээ нь, Өвлийн ордон гэх мэт)

Дурсгалын бүртгэлийн дугаар: (Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сангийн Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн дугаар болох 10-12 оронтой тоог бичнэ үү. Жишээ нь, 11 22 001 5 15)

### МД- Мөрийн дугаар

- 4.1. **Ажил гүйцэтгэсэн хугацаа:** Ажил гүйцэтгэхдээ хэдий хэр хугацаа зарцуулсан болохыг эхэлсэн он/сар/өдөр болон дууссан он/сар/өдөр дарааллаар бичнэ үү.
- 4.2. **Төсөвт өртөг (сая.төг):** Сэргээн засварлалтын ажлыг хэдэн төгрөгөөр, ямар байгууллага санхүүжилт хийсэн тухай бичнэ үү.
- 4.3. **Сэргээн засварлах ажлын зураг төсөл гүйцэтгэсэн байгууллага:** Сэргээн засварлах ажлын зураг төсөл гүйцэтгэсэн байгууллагын нэрийг бичнэ үү. Ажлын зурагт өөрчлөлт орсон бол тэр тухай мэдээллийг мөн оруулна уу.
- 4.4. **Сэргээн засварлах ажил гүйцэтгэсэн байгууллага:** Сэргээн засварлах ажил гүйцэтгэсэн байгууллагын нэрийг бичнэ үү. Гүйцэтгэгч байгууллагад өөрчлөлт орсон бол тэр тухай мэдээллийг мөн оруулна уу.
- 4.5. **Барилгын ажлын зураг, төсөвт өртгийн тооцооны эх хувийг хадгалж байгаа газар:** Барилгын ажлын зураг, төсөвт өртгийн тооцоог Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 21.2.10 заалтыг үндэслэн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хадгалуулах ёстой. Хэрэв дээрх байгууллагаас өөр газарт хадгалагдаж байгаа тохиолдолд тухайн байгууллага, хувь хүний нэр, албан тушаал, ажлын зургийн нэрийг бичнэ үү.
- 4.6. **Сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг хадгалж байгаа газар:** Сэргээн засварласан ажлын дэлгэрэнгүй тайланг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 47.3 заалтыг үндэслэн Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан, архивд хадгалуулах ёстой. Хэрэв эдгээр байгууллагаас өөр газарт хадгалагдаж

байгаа тохиолдолд тухайн байгууллага, хувь хүний нэр, албан тушаал, тайлангийн нэрийг бичнэ үү.

**4.7. Гэрэл зураг** (хавсралтаар): Гэрэл зургийг 4 талаас нь бүрэн бүтэн, аль болох халхлах зүйл (хүн, машин гэх мэт)-гүй орчинд авна. Зураг тус бүр 12х16см хэмжээтэй байх ба өнгөтөөр чанартай хэвлэсэн байна. Сэргээн засварлалт хийхээс өмнө, хийх явцад, хийсний дараа гэж 3 (гурав) ангилан цаасан дугтуйд хийнэ. Зургийн тайлбарыг хамт хавсаргана уу.

--- хХх ---